

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТУХАЙ
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТУХАЙ ТАЙЛАН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тамхины чимээгүй тахалтай тэмцэх асуудал зөвхөн хүний эрүүл мэндийн асуудал төдийгүй бүхэл бүтэн улс, үндэстэн, дэлхий нийтийн хөгжлийн тулгамдсан асуудал болж байгаа тул Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага /ДЭМБ/-аас 2003 онд “Тамхины хяналтын суурь конвенцийг боловсруулж, 2005 оноос эхлэн хүчин төгөлдөр болон хэрэгжиж байна. ДЭМБ-аас тус Конвенци болон түүнийг дагаж батлагдсан найман Удирдамж, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протоколыг батлан мөрдөхийг Гишүүн улс орнуудад зөвлөмж болгодог.

Өнөөгийн байдлаар тус конвенцид 182 улс орон нэгдэж, дэлхийн нийт хүн амын 90 гаруй хувь тамхины хяналтад орж, улс орон бүр олон талт бодлого, арга хэмжээг үндэсний хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна. Энэхүү конвенци нь тамхины хэрэглээ болон тамхины утаанд нэрвэгдэх явдлыг бууруулах, тамхидах тахлын эрүүл мэнд, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн үр дагавраас одоо ба хойч үеийнхнийг хамгаалах зорилготой нийгмийн эрүүл мэндийн анхны олон улсын хууль эрх зүйн баримт бичиг юм.

Монгол Улс энэхүү конвенцийг дэмжин Монгол Улсын Засгийн газар 2003 оны 6 дугаар сарын 16-ны өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурал тус конвенцийг мөн оны 10 дугаар сарын 24-ний өдөр соёрхон баталж, Нэгдсэн Үндэстний Байгууллага 2004 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр албан ёсоор бүртгэж авч Монгол Улсад 2005 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөж байна. Тус Тамхины хяналтын суурь конвенцийн Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протокол”-ыг Улсын Их Хурал 2014 онд соёрхон баталсан.

Тамхины хяналтын суурь конвенцийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтад “... бүс нутгийн болон олон улсын хэлэлцээрээс гадна үндэсний хууль тогтоомжийг боловсруулж хэрэгжүүлэх нь тамхины хяналтын салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд мөн ...” гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурал анх 1993 онд Тамхины хяналтын тухай хуулийг баталсан ба Монгол Улсын Засгийн газраас Тамхины хяналтын суурь конвенцийн ерөнхий зарчим, арга хэмжээнүүдийг дотоодынхоо нөхцөл байдалтай уялдуулан уг хуулийг шинэчлэн найруулж боловсруулсныг 2005 оны 07 дугаар 01-ний өдөр баталсан байна. Тамхины хяналтын тухай хуульд 2012 онд 1 удаа, 2015 онд 3 удаа, 2019 онд 1 удаа, нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээрээс 2015 оны 01 дүгээр 29-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын гишүүн,

бусад нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын засгийн газраас тус тус санаачилсан байна.

НҮБ-ын 2015-2030 он хүртэлх “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-өөр нийт хүн амыг насан туршид эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах зорилтыг дэвшүүлсэн бөгөөд тус хөтөлбөрийн 3а-д “тамхины хяналтын суурь конвенцийн хэрэгжилтийг сайжруулах”, мөн хөтөлбөрийн 3.4-т тамхинаас шалтгаалах өвчлөл болох зүрх судасны өвчин, амьсгалын замын бөглөрөлт өвчлөл, хавдар зэрэг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт бус өвчнөөс нас барах явдлыг 2030 он гэхэд гуравны нэгээр бууруулах, тамхины хэрэглээг 30 хувь бууруулахаар тогтсон.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ

Тамхины хяналтын тухай хуульд 2012 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш насанд хүрэгсдийн тамхины хэрэглээний тархалтыг тогтоох үндэсний судалгааг 2 удаа, өсвөр насныхны тамхины хэрэглээний судалгааг 2 удаа, Монгол Улсын тамхины хяналтын хууль эрхзүйн орчны зохицуулалтын үнэлгээг 3 удаа хийлгэсэн байна. Хүн амын дунд явуулсан дээрх судалгааны дүн, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтээс харахад тамхины хэрэглээ, хангамжийг зохицуулж байгаа Тамхины хяналтын тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага тулгарсныг харуулж байна. Эдгээр үнэлгээ, судалгааны үр дүнг товч дурдья.

Нэгдүгээрт: Хүн амын дунд тамхины хэрэглээний тархалт буурахгүй, эдгээрээс шалтгаалсан өвчлөл тасралтгүй нэмэгдэж байгааг дараах эрүүл мэндийн үзүүлэлт, үндэсний судалгаа харуулж байна.

Тамхи нь 4000 гаруй химийн хортой бидис, түүнээс 60 гаруй хорт хавдар үүсгэдэг химийн хортой, донтуулдаг бодистой, тамхи хэрэглэгчдийнхээ тал хувийг нь үхэлд хүргэдэг, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хор хөнөөлтэй бүтээгдэхүүн юм.

Тамхи нь халдварт бус өвчлөлийн үндсэн шалтгаан болдог. Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн 2020 оны үзүүлэлтээс харахад хүн амын нас баралтын шалтгааны 85.9%-ийг Халдварт бус өвчин (ХБӨ) эзэлж, үүний дотор 3 хүний нэг нь зүрх судасны тогтолцооны өвчин, 4 хүний нэг нь хавдар, 5 хүний нэг нь гэмтэл хордлого, гадны шалтгааны улмаас нас барж байгаа нь анхаарал хандуулах эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал болсоор байна.

2020-2021 онд Монгол Улсад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хийсэн “Тамхины хяналтын суурь конвенцийн хөрөнгө оруулалтын үр өгөөж судалгаа”-ны дүнгээр жил бүр тамхинаас шалтгаалсан 4300 нас баралт байгаа нь 70-аас доош насны нас баралтын 72 хувийг эзэлж, нийт нас баралтын 17 хувийг эзэлж байгааг тогтоосон. Мөн тамхитай холбоотой эрүүл мэндийн нийт зардал нь жилд 857 тэрбум төгрөг (ДНБ-ний 2,3 хувь) зарцуулж байгаагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шууд зардал нь

143 тэрбум төгрөг, шууд бус өртөг нь (эрт нас баралт, тамхинаас үүдэлтэй өвчний улмаас ажилдаа ирэхгүй байх, хөдөлмөрийн чадвар буурах г.м) 714 тэрбум гэж болж байгаагаас харахад сэргийлэх боломжтой эрүүл мэндийн эдийн засгийн алдагдал асар их байна.

НҮБ-ын шинжээчдийн 2017 онд Монгол Улсад хийсэн “Халдварт бус өвчний хөрөнгө оруулалтын үр өгөөж судалгаа”-гаар манай хүн амын нийт нас баралтын шалтгааны 77%-ийг ХБӨ, тэдгээрийн 32% нь 30-70 насныхныг хамран цагаас эрт нас барж байгааг тогтоожээ. Судалгааны энэхүү үзүүлэлтийг бага болон дунд орлоготой бусад оронтой харьцуулахад манай улс дэлхийд ХБӨ өндөр тархалттай 2 дахь орон болж байна гэж дүгнэсэн. Түүнчлэн өвчлөлийн архагшсан, хожуу үед өртөг өндөртэй оношилгоо, эмчилгээ хийж, үүнд эрүүл мэндийн салбарын төсвийн 70 гаруй хувийг зарцуулж байгааг дээрх үнэлгээгээр тогтоож, тамхидалттай тэмцэх замаар халдварт бус өвчин буурах боломжтой бөгөөд энэ нь урт хугацаанд үр өгөөжөө өгөх, эдийн засгийн үр ашигтай арга хэмжээ болохыг тогтоосон байна.

Урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой халдварт бус өвчний эрсдэлт 4 гол хүчин зүйлийн нэг нь тамхи юм. ДЭМБ-ын шаталсан судалгааны аргачлалын дагуу Монгол Улсын 15-64 насны хүн амыг хамруулсан “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох үндэсний судалгаа”-г 2005, 2009, 2013, 2019 онд зохион байгуулж тогтмол тандалт хийж байна. 2019 оны судалгаагаар судалгаанд хамрагдсан хүн амын тамхины хэрэглээ 24.2%-тай, үүнээс эрэгтэйчүүдийн 44.7%, эмэгтэйчүүдийн 5.0% нь тамхи хэрэглэж байна. Хүйсийн ялгаатай байдлаар авч үзэхэд эрэгтэйчүүдийн тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс даруй 8-9 дахин байна. Судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 3 нь (32.8%) гэрийн дотоод орчинд, 4 хүн тутмын 1 нь (22.6%) ажлын байрандаа дам тамхидалтад өртөж байна.

Хүүхэд, өсвөр насныхны дундах тамхины хэрэглээ ч буурахгүй байна. Монгол Улс ДЭМБ болон Америкийн Нэгдсэн Улсын Өвчин Судлалын Төвөөс хамтран боловсруулсан судалгааны нэгдсэн аргачлалаар “Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа”-г 2003, 2007, 2014, 2019 онд хийсэн байна.

2019 оны судалгаагаар сурагчдын 14,1 хувь нь ямар нэгэн тамхи татдаг бөгөөд үүнд янжуур тамхины хэрэглээ 22.3 хувь—гэж гарсан нь 2014 онтой харьцуулахад 6.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Нийт сурагчдын 8.2% нь утаагүй тамхин бүтээгдэхүүн татдаг, 42.1% нь ямар нэг хэмжээгээр утаагүй тамхийг хэрэглэж үзсэн, хүүхдүүдийн 3.5% нь электрон тамхи хэрэглэж байна.

Дээрх судалгаануудад хамрагдсан өсвөр насныхны 85.6% нь, насанд хүрэгсдийн 40.6% нь тамхиа хаях оролдлого хийсэн байгаа бөгөөд тамхи хаяхыг хүсэх, оролдлого хийх хувь өмнө онуудтай харьцуулахад харьцангуй тогтмол байгаа нь эерэг үзүүлэлт юм. Насанд хүрэгсдийн 4.6% нь л тамхинаас гарчээ.

Түүнчлэн нийт сурагчдын 52.3% нь сүүлийн 7 хоногт олон нийтийн газрын дотор хаалттай орчинд тамхины утаанд өртөж байсан бөгөөд тэдний 84.3% нь олон нийтийн газруудын дотор талд, 82.8% нь олон нийтийн газруудын гадна талд тамхи татахыг хориглохыг дэмжсэн байна.

Сүүлийн 30 хоногт тамхи татдаг сурагчдын 69.4% нь, насанд хүрэгчдийн 88.0% нь тамхины хайрцаг дээрх эрүүл мэндийн сэрэмжлүүлгийг анзаарч харсан, тамхи татдаг нийт сурагчдын 42.8% нь, насанд хүрэгчдийн 59.7% нь тамхи татахаа болих тухай бодсон байна.

Хоёрдугаарт: Тамхины хяналтын суурь конвенцийн Нарийн бичгийн даргын газар 2015 оны 7-9 дүгээр сард Монгол Улсад ажиллаж “ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийг хэрэгжүүлэх хэрэгцээний үнэлгээ”-г хийж Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж өгсөн.

Монгол Улс Тамхины хяналтын суурь конвенцийг 2003 оны 6 дугаар сарын 16-ны өдөр соёрхон баталснаар уг конвенцийн гишүүн болсон дэлхийн 6 дахь улс, Номхон далайн баруун бүсийн 2 дахь улс болж, улмаар уг конвенцийг 2004 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Гэсэн хэдий ч Монгол Улс ДЭМБ-ын ТХСК-ийг бүрэн хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлууд хэвээр байгааг харгалзан Тамхины хяналтын суурь конвенцийн Нарийн бичгийн даргын газраар ахлуулсан, ДЭМБ-ын Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх газар болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төлөөллөөс бүрдсэн олон улсын шинжээчдийн баг Монгол Улсад ажиллаж, Конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын сүүлийн үеийн тайлан болон мэдээллийн бусад эх сурвалжийг ашиглан өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, хэрэгцээнд урьдчилсан дүн шинжилгээг 2015 оны 7-9 дүгээр саруудад зохион байгуулсан.

Хэрэгцээний үнэлгээний тайланд Конвенцийн зүйл, заалт тус бүрийн хэрэгжилтийн байдал, орхигдсон асуудлыг тодорхойлж, Монгол Улс Тамхины хяналтын суурь конвенцийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх шаардлагатай үндсэн арга хэмжээг тодорхойлж, бодлогын баримт бичиг боловсруулахдаа ашиглах 14 чиглэлийн зөвлөмж өгсөн байна.

Тус зөвлөмжөөс Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэх шаардлагатай дараах зөвлөмжийг түүвэрлэн оруулж байна. Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газар Тамхины хяналтын суурь конвенцийг бүрэн хэрэгжүүлж олон нийтийн газар тамхи татахыг бүрэн хориглох талаар ихээхэн амжилт гаргасан байна. Гэвч тус хуульд 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, сан нь тамхины хяналтын талаар олсон амжилтаасаа ухарсан хэрэг болсон гэж дүгнэлээ. Тамхины хяналтын тухай хууль (4.1.2, 4.1.3, 4.1.6, 4.1.8, 4.1.9, 5.1.3–5.1.5 ба 5.2.3 дахь заалтууд) нь нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхи үйлдвэрлэгчдийн сөрөг нөлөөллөөс хамгаалахыг зорьдог байна.

2.Гэсэн хэдий ч тамхи үйлдвэрлэгчид өндөр түвшний бодлого боловсруулагч нарт үзүүлэх нөлөө ихтэй байгаа тул хуулийн зохицуулалтыг сулруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг хийж амжин 2015 онд тус хуульд өөрчлөлт оруулснаар ТХСК-ийн зөвлөмжөөс ухарсан байна. Үүний улмаас олон нийтийн газар тамхи татахыг бүрэн хориглохтой холбоотой хуулийн зохицуулалт суларсан байгаа тул ТХСК-ийн 5.3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах,

3.ТХСК-ийн дагуу хүнийг олон нийтийн бүх газрын дотоод орчинд тамхины утаанд өртөхөөс хамгаалах үүргийг Монгол Улс хүлээсэн бөгөөд Тамхины хяналтын тухай хуулийн 2.2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.” гэжээ. Олон нийтийн газрын дотоод орчинд 100% тамхигүй орчин бүрдүүлэхийг ТХСК шаарддаг. Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуульд 2015 онд оруулсан олон нийтийн газарт тамхи татах зөвшөөрөгдсөн цэг байгуулах тухай нэмэлт өөрчлөлтүүдээс илүү ТХСК нь хууль зүйн хүчин чадалтай. Тамхины хяналтын тухай хуульд 2015 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг эргэн харж, олон нийтийн газрын дотоод орчин, нийтийн тээвэр, ажлын байранд 100% тамхигүй орчин бүрдүүлэх ТХСК-ийн 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэх,

4.Тамхины хяналтын тухай хууль (6.4–6.6, 6.7.1, 6.7.3, 6.7.5, 6.7.6, 6.7.11 дэх заалт), Монгол Улсын MNS 5024:2013, MNS6274:2013 стандартын дагуу тамхи үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагчид тамхины шошгололт, эрүүл мэндийн анхааруулгатай холбоотой стандартыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэвч эдгээр хууль, стандартын дагуу тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, боодол дээр тамхины найрлагад агуулагдах бохь, никотины хэмжээ болон дуусгавар болох хугацааг заахыг шаарддаг байна. Мөн усан тамхи, электрон тамхины хуулийн зохицуулалт байхгүй, эдгээрийн хувьд сав, баглаа, боодол, шошгололтын стандартыг мөрдөх шаардлага тавьдаггүй байна. Иймд ТХСК-ийн 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид нийцүүлэн Тамхины хяналтын тухай хууль болон стандартад нэмэлт, өөрчлөлт оруулахыг Засгийн газарт зөвлөмж болгож байна. Түүнчлэн усан тамхи, электрон тамхины асуудлыг хууль тогтоомжид тусгах,

5.Тамхины хяналтын тухай хууль (8 дугаар зүйл,6.7.6, 6.7.10 ба 6.7.13 дахь заалт)-д заасанчлан Монгол Улсад тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг бүрэн хориглосон. Гэвч хуулийн 8.1.7 дахь заалтад тамхи борлуулах цэгт тамхины нэр, үнэ, тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн тавихыг зөвшөөрсөн байна. Түүнчлэн тамхин бүтээгдэхүүнийг үнэгүй тараахыг хориглосон заалт байхгүй, электрон тамхийг интернэтээр зарах боломжтой байна. Иймд ТХСК-ийн 13 дугаар зүйлд нийцүүлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах,

6.Тамхины хяналтын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа нь хууль, тогтоомжийн үр дүнтэй байдлыг сулруулж байна. Иймд ЭМЯ-ны зүгээс мэргэжлийн хяналт, гааль, цагдаа болон хууль сахиулах бусад байгууллагатай хамтарч Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангахыг зөвлөмж болгож байна. Мөн холбогдох яам, агентлагийн хууль сахиулах чиг үүрэг бүхий албан хаагчдыг сургалтад хамруулах шаардлагатай. Түүнчлэн тамхигүй орчин бүрдүүлэх талаар шийдвэр гаргахад нь орон нутгийн засаг захиргаанд дэмжлэг үзүүлэхийг зөвлөмж болгож байна.

7.Янжуур тамхинд ногдуулах татвар Монгол Улсад жижиглэнгийн үнийн 42.4%-тай байгаа нь Сингапур (66%), Филиппин (74%) зэрэг улстай харьцуулахад бага юм. Мөн 20 ширхэгээр савласан янжуур тамхины үнэ хямд буюу 3000 орчим төгрөг (1.5 ам.доллар) байгаагаас тамхи худалдан авах эрэлт их байна. Үүний улмаас Монгол Улс ТХСК-ийн 6 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн зорилтууд болон гишүүн

орнуудын 6 дугаар хурлаар баталсан холбогдох Удирдамжуудыг хэрэгжүүлж чадахгүйд хүрч байна. Иймд ТХСК-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварыг нэмэхийг Монгол Улсад зөвлөмж болгож байна.

8.Энэхүү тайланд тодорхойлсон хэрэгцээ, шаардлага нь нэн даруй анхаарал хандуулах ёстой тэргүүлэх чиглэл бөгөөд Гишүүн орнуудад хэрэгжүүлэх хугацаа олгосон зүйл, заалтууд (8, 11 ба 13 дугаар зүйл)-тай холбоотой арга хэмжээнүүд юм. Энэхүү тайланд дэвшүүлсэн асуудлуудыг шийдвэрлэх нь Монгол Улсын хувьд ТХСК-ийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болох бөгөөд хүн амын эрүүл мэнд, амьдралын чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой байна.

Гуравдугаарт: Тамхины хяналтын бодлогын нэг хэсэг нь тамхи импортлолт, үйлдвэрлэлийн хяналт байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр “IX.2. Архи, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг импортлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан ил тод сонгон шалгаруулалт явуулах зарчмаар шийдвэрлэж байх чиглэлээр судлан, холбогдох журмын төслийг боловсруулж, Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг даалгав.” гэжээ.

Тамхины импортын салбарт тулгамдаж буй асуудал нь импортлох тамхины нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан ил тод сонгон шалгаруулалт явуулах талаар эрх зүйн зохицуулалт байхгүйгээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны судалгаанаас харахад янжуур тамхи импортлох 52, дүнсэн тамхи импортлох 21 аж ахуйн нэгж, иргэнд тусгай зөвшөөрөл олгосон байгаа явдал бөгөөд тамхины импортын хэмжээ жилээс жилд өсөх төлөвтэй байгаа болно.

Тамхины импорт болон үйлдвэрлэлийн хэмжээ

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Тамхины үйлдвэрлэл янжуур мян.блок	6432,4	5086,3	4959,2	5397,4	4721,5
Тамхины импорт янжуур сая ш	2042,9	2026,2	2247,1	2901,7	2550,3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл 2014-2018

Өнөөгийн байдлаар тамхи импортлох тусгай зөвшөөрөлтэй 14 аж ахуйн нэгж байна. Иймд тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлт гаргаагүй бол тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцох заалтыг хуульд тусгах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

“Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгахаар заасан боловч тамхи импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг заагаагүй тул хуульд тусгах нь зүйтэй байна.

ТХСК-ийн Нарийн бичгийн дарга нарын газраар удирдуулсан НҮБ-ын төрөлжсөн агентлагын хамтарсан баг Монгол Улсад 2015 онд хийсэн “ТХСК-ийн хэрэгжилтийн үнэлгээ”-нд тамхины хэрэглээ буурахгүй байгаа нь хуулийн нарийвчилсан зохицуулалт, хуулийн хяналтын механизм тодорхойгүй байгаатай холбоотойг дурдаж зөвлөсөн.

1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд

Дээрх асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлэг, иргэд, аж ахуй нэгжийг дараах байдлаар тодорхойлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөө буюу эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдолоос хамгаалуулах, эрүүл мэндээ хамгаалах гэж заасан.

Тамхи нь хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт хор хөнөөлтэй бүтээгдэхүүнд ордог. Ширхэг тамхи ч хортой бөгөөд ялангуяа тамхи татдаггүй хүн тамхины утаанд өртөх нь илүү сөрөг нөлөөтэйг ДЭМБ тогтоосон. Тамхинд 4400 гаруй хортой химийн бодис байдаг бөгөөд эдгээрийн 60 гаруй нь хүнд хорт хавдар үүсгэх сөрөг нөлөөтэй бөгөөд 2019 оны үндэсний судалгаагаар нийт хүн амын 75,8 хувь тамхи татдаггүй боловч эрүүл агаараар амьсгалах тэдний эрүүл мэндийн эрх зөрчигдөж байна.

Түүнчлэн тамхи хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалж, хорт зуршилд автахгүй байх, тамхинаас татгалзахыг дэмжсэн орчин бүрдүүлэхэд Тамхины хяналтын тухай хууль чухал нөлөөтэй.

Тамхи бол хүнс, амьдралын чухал хэрэглээ биш, тамхи нь донтуулдаг, хэрэглэгчийнхээ тал хувийг үхэлд хүргэдэг хортой бүтээгдэхүүн учраас тамхи хэрэглэгчдийг тамхинаас гарахад туслах, тэдний эрүүл мэндийг хамгаалах нь төрийн үүрэг байдаг. Тамхинаас шалтгаалсан халдварт бус өвчнөөр 10 хүний 7 нь өвдөж байна. 2019 онд хийгдсэн “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох шаталсан судалгаа”-гаар тамхины хэрэглээ 24.2%-тай, үүнээс эрэгтэйчүүдийн 44.7%, эмэгтэйчүүдийн 5.0% нь тамхи хэрэглэж байгаа бол 2019 оны “Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа”-гаар өсвөр насныхны 14.1 хувь нь ямар нэгэн тамхи татдаг бөгөөд үүнд янжуур тамхины хэрэглээ 22.3 хувьтай гарсан нь 2014 онтой харьцуулахад 6.7 хувиар нэмэгдсэн байна.

Дээрх судалгаануудад хамрагдсан өсвөр насныхны 85.6% нь, насанд хүрэгсдийн 40.6% нь тамхиа хаях оролдлого хийдэг боловч насанд хүрэгсдийн 4.6% нь л тамхинаас гарч чаджээ. Түүнчлэн тамхины хайрцаг дээрх эрүүл мэндийн сэрэмжлүүлэг мэдээллийг хараад тамхи хэрэглэгчдийн 59.7% нь тамхинаас татгалзах талаар бодсон байна. Тамхи хэрэглэгчдийн 29.4% нь эмч, эмнэлгийн ажилтнаас тамхинаас гарах талаар зөвлөгөө авч байсан байна. Тамхи хэрэглэгчид тамхи татах

хүсэлгүй байгаа бөгөөд тамхийг хаяхыг дэмжих эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан насанд хүрэгсдийн 10 хүн тутмын 3 нь (32.8%) гэрийн дотоод орчинд, 4 хүн тутмын 1 нь (22.6%) ажлын байрандаа дам тамхидалтад өртөж байна. Иймд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж олон нийтийн газар, дотоод орчныг 100% тамхигүй орчин болгон, тамхины утаанд өртөхөөс иргэд, хүүхэд залуучуудыг хамгаалах, тэдний эрүүл байх, эрүүл агаараар амьсгалах нөхцөлийг бүрдүүлэх, хорт хавдар, зүрх судасны өвчлөл, амьсгалын замын өвчлөл зэрэг 200 гаруй өвчнөөс эрт өрсөн хамгаалах нөхцөл бүрдүүлж, тамхины эрэлтийг бууруулах, нийгэм эдийн засагт үзүүлж байгаа дарамт, сөрөг нөлөөллийг бууруулах, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилтыг хангах, ТХСК бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

Тамхины хэрэглээг бууруулахад тамхин бүтээгдэхүүний хангамжийн хяналт, оновчтой зохицуулалт чухал байр суурь эзэлнэ. 2015 оны байдлаар Засгийн газраас олгосон янжуур тамхи импортлох тусгай зөвшөөрөлтэй 52, дүнсэн тамхи импортлох 24 тусгай зөвшөөрөлтэй 21 аж ахуйн нэгж, иргэн байгаа /Эх сурвалж: АҮЯ-ны 2015 оны 01/696 дугаар албан бичиг/ боловч өнөөгийн байдлаар тамхи импортлох тусгай зөвшөөрөлтэй 14 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь идэвхтэй, бусад нь зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч сунгах, цуцлах зохицуулалт, хяналтыг оновчтой болгох шаардлагатай байна.

ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийн хүрээнд тамхины тариаланг багасгаж, аажмаар ажилчдыг тамхинаас өөр амьжиргааны тогтвортой эх үүсвэрээр хангах шинэлэг механизм бүрдүүлэх бодлого баримталж, хүнсний баталгаат байдал, зохистой зах зээл, үүн дотроо тамхины тариалалтыг орлуулах байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихтэй уялдсан хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байгаа тул Монгол Улсад тамхины ургамал тариалах боломж олгож байгаа хуулийн заалт байхгүй байх нь зөв юм.

1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Тамхины хяналтын тухай хуульд 2012 онд нэмэлт, өөрчлөлт оруулж тамхины хүртээмж, утаанд өртөлтийн хязгарлалтыг нэмэгдүүлж, тамхины хор хөнөөлийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг хийж, тамхинд ногдох онцгой албан татварыг 20 хувиар нэмсэн ч дээр дурдсан судалгаа, үнэлгээнээс үзэхэд тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах нийтлэг шалтгаан, нөхцөл харагдаж байна.

Нэгдүгээрт, Тамхины хяналтын тухай хуульд оруулсан 2012 оны нэмэлт, өөрчлөлтөөр олон нийтийн газар, байгууллагын дотоод орчинд утаат тамхи татахыг хориглож тамхины утааны хор хөнөөлөөс иргэдийг 100 хувь хамгаалах орчин бүрдүүлсэн. Гэвч УИХ-ын гишүүний санаачилсан 2015 оны нэмэлт, өөрчлөлтөөр үйлчилгээний газар болон байгууллагын дотор тамхи татах өрөө байгуулахаар шийдвэрлэсэн нь ТХСК-ийн зарчим, ТХСК-ийн 8 дугаар Удирдамжийн зохицуулалтын эсрэг дам тамхидалтыг дэмжсэн шийдвэр болсон гэж НҮБ-ын шинжээчид дүгнэсэн. Монгол улсад хийгдсэн Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг

тогтоох 2019 оны судалгаагаар ажлын байранд тамхины утаанд өртөх явдал 26 хувь, Дэлхийн залуучуудын тамхины хэрэглээг тогтоох 2019 оны судалгаагаар нийт сурагчдын 52.3% нь сүүлийн 7 хоногт олон нийтийн газрын дотор хаалттай орчинд тамхины утаанд өртөж байсан бол тэдний 84.3% нь олон нийтийн газруудын дотор талд, 82.8% нь олон нийтийн газруудын гадна талд тамхи татахыг хориглохыг дэмжсэн байна. Иймээс дотоод орчныг 100% тамхигүй орчин болгож, аливаа аж ахуйн нэгж, байгууллага, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн орон сууц, нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газрын орох хаалганы гадна талаас 10-50 метрийн зайд тамхи татах цэгийг байгуулж албан хаагчид, үйлчлүүлэгчдийн тамхины утаанд өртөлтийг багасгах арга хэмжээ авах.

Хоёдугаарт, Дэлхийн 192 оронд уламжлалт (янжуур, дүнсэн тамхи) тамхины хяналт чангарч тамхины хэрэглээ буурч байгаатай холбоотойгоор хуулийн зохицуулалтад хамрагдаагүй тамхины шинэ төрлүүд(электрон тамхи, халаадаг тамхи, зажилдаг тамхи, усан тамхи) гарч байна. Тамхи үйлдвэрлэгчдийн маркетингийн арга шинэчилэгдэн Монгол улсад төдийгүй дэлхийн зах зээлд халаадаг тамхи, электрон тамхи, усан тамхи, навсай гэх мэт олон төрлийн шинэ тамхины төрөл зах зээлд нэвтэрч, худалдаагаа өргөжүүлэх стратеги баримталж байна. Эдгээр тамхи нь бох, никотин болон бусад химийн хортой бодис агуулсан байдгийг ДЭМБ тогтоож, бусад тамхины адил хуулийн зохицуулалтад оруулахыг зөвлөдөг. Шинээр гарч ирж байгаа, дахин сэргэж байгаа тамхи нь Тамхин хяналтын тухай хуулийн зохицуулалтад тусгагдаагүй, цахилгаан бараа нэрийн дор онцгой албан татвар төлдөггүй, тамхинаас гаргах бэлдмэл гэдэг ташаа сурталчилгаа, гадаад үзэмжээсээ нь болж өсвөр үе, залуучууд их хэрэглэж байна. Иймээс НҮБ-ын шинжээчид усан тамхи, электрон тамхины асуудлыг хууль тогтоомжид тусгахыг зөвлөсөн бөгөөд тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтод утаат, утаагүй тамхи, шинэ болон шинээр гарч ирж байгаа тамхины төрлүүдтэй холбоотой тодорхойлолтыг тусган хуулийн бусад зохицуулалтад хамруулах,

Гуравдугаарт, Тамхины хайрцагны сав, баглаа, боодол дээрх сэтгэл татам өнгө, хараа булаасан загвар, анхаарал татах дүрс нь нь худалдан авах сэдэл төрүүлдэг, хэрэглэгчдийн анхаарлыг татдаг, тамхи татдаггүй хүмүүс, ялангуяа хүүхдүүд тамхи татаж эхлэхэд нөлөөлдөг, тамхины хор хөнөөлийг өнгөлөн далдалдаг тамхи үйлдвэрлэгчдийн маркетингийн гол арга байдаг. Тамхин бүтээгдэхүүний сав, баглаа боодлын загвар хийцэд анхаарснаар тамхины брэндийг сурталчлах, борлуулалтыг өдөөхийн зэрэгцээ тамхины аюул эрсдлийн бодит байдал, аюулын талаар хэрэглэгчдийг төөрөгдүүлэхэд хүргэдэг. Тамхины хяналтын суурь конвенцийн 13 дугаар зүйлд “Тамхи, тамхин бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошго, түүнчлэн тамхи, бусад тамхин бүтээгдэхүүн нь өөрөө танилцуулга болон зар сурталчилгаа болох, хүний анхаарал, сонирхлыг татах загвар хийцтэй байж болохгүй.” гэж заасан. Тамхины эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө, эрсдлийг таниулж, эрүүл мэндийн анхааруулгатай болгох нь тамхин бүтээгдэхүүний хэрэглээний эрэлт, сонирхлыг бууруулж, хэрэглээний төөрөгдлийг хязгаарлах үр дүнтэй арга хэмжээ юм (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2016он). ТХСК-ийн 11 дүгээр Удирдамжид зөвлөснөөр тамхины хайрцаган дээр тамхины хор хөнөөлийн талаар зурган болон бичвэр анхааруулгыг том хэжээтэйгээр, тамхины хайрцагны эргэн тойрны гадаргуй, ялангуяа гадаргуйн доод бус дээд талд нь байрлуулах эсвэл тамхины хайрцагийг цулгуй болгохыг зөвлөдөг. Судалгаагаар тамхи татдаг сурагчдын 69.4% нь, насанд

хүрэгчдийн 88.0% нь тамхины хайрцаг дээрх эрүүл мэндийн сэрэмжлүүлгийг анзаарч харсан, тамхи татдаг нийт сурагчдын 42.8% нь, насанд хүрэгчдийн 59.7% тамхи татахаа болих тухай бодсон байгаа нь тамхи хаях сэдэл төрөх, тамхи хаях оролдлого хийх, тамхийг хаяхад нөлөөлдгийг судалгаа харуулж байна. Иймээс тамхины хор хөнөөлийн зурагт анхааруулгыг ТХСК-ийн 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид нийцүүлэн тамхины хайрцагны ар болон нүүрэн талын талбайн хэсгийн 50%-иас дээш эзэлсэн байхаар, бичвэр анхааруулгыг тамхины хайрцагны онгойдог тагны нүүрэн талд байрлуулах зохицуулалт хийх, амхины хяналтын тухай хууль болон стандартад нэмэлт өөрчлөлт оруулахыг Засгийн газарт зөвлөмж болгож байна.

Дөрөвдүгээрт, ТХСК-ийн 13 дугаар Удирдамжид “тамхин бүтээгдэхүүний борлуулалтын цэгүүдэд сурталчилгааны аливаа элемент байлгахгүй байх явдлыг хэвшүүлэхийн тулд Оролцогч талууд жижиглэн худалдааны дэлгүүр болон гудамжны мухлаг зэрэг тамхин бүтээгдэхүүн борлуулдаг цэгүүдэд тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн харуулахыг бүрмөсөн хориглох” гэж заасан. НҮБ-ын шинжээчдийн үнэлгээгээр “Тамхины хяналтын тухай хууль (8 дугаар зүйл, 6.7.6, 6.7.10 ба 6.7.13 дахь заалт)-д заасанчлан Монгол Улсад тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг бүрэн хориглосон. Гэвч хуулийн 8.1.7 дахь заалтад тамхи борлуулах цэгт тамхины нэр, үнэ, тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн тавихыг зөвшөөрсөн байна. Түүнчлэн тамхин бүтээгдэхүүнийг үнэгүй тараахыг хориглосон заалт байхгүй, электрон тамхийг интернэтээр зарах боломжтой байна. Иймд ТХСК-ийн 13 дугаар зүйлд нийцүүлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвлөсөн. Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн 8.1.7-д тамхи борлуулах цэгт тамхины нэр, үнэ, тамхин бүтээгдэхүүнийг дэлгэн тавихаас бусад хэлбэрээр мэдээлэл өгөхийг хориглосон байна. Энэ нь нэг талаас тамхин бүтээгдэхүүнийг сурталчилахыг хориглосон заалт мэт боловч тамхи худалдаалагчдын борлуулалтыг сурталчилсан заалт юм. Үүнтэй холбоотойгоор тамхийг хүнсний дэлгүүр, супермаркетийн кассны хажууд нүдэнд харагдахуйц газар байршуулан зарж байгаа нь тамхи татах сэдлийг бий болгон хүүхэд залуучуудын анхаарлыг татах, хэрэглээг нэмэгдүүлэх, худалдааг өргөжүүлж байна. Хэдийгээр тамхины хэрэглээ 2013 онтой харьцуулахад 2.9 хувиар буурсан хэдий боловч судалгаагаар өдөр бүр тамхи татдаг хүний эзлэх хувь 2013 онд 19.3 хувь байсан бол 2019 онд 21.6 хувь болж нэмэгдсэн, тамхи татаж эхэлсэн дундаж нас 2013 онд 19.7 байсан бол 2019 онд 18.9 болж залуужсан, үйлдвэрийн тамхи хэрэглэдэг хүн ам 2013 онд 2013 онд 95.2 байсан бол 2019 онд 96.8 болж өссөн байна. 2019 оны Дэлхийн залуучуудын/13-15 нас/ тамхины хэрэглээг тандах үндэсний 4 дэх удаагийн судалгаагаар сурагчдын 82 хувь нь дэлгүүр, супермаркет, түргэн үйлчилгээний цэгээс худалдан авдаг байна. Эдгээрээс харахад тамхийг ил байршуулан худалдаалж байгаа нь шууд сурталчилгаа болж тамхины хэрэглээ залуужих, хэрэглээ нэмэгдэхэд нөлөөлж байна. Түүнчлэн нийгмийн сүлжээ, импортоор орж ирж байгаа болон дотоодын кино, нэвтрүүлгээр тамхи татаж байгаа дүрс гарган сурталчилж байна. Иймээс тамхи татах донг сэдэрээх байдлыг бууруулах зорилгоор бренд өргөтгөх бүх төрлийн зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тамхийг биет байдлаар ил харагдахааргүй байдлаар байршуулж, тусгайлан зориулагдсан, зохих хаалттай тавиурт худалдаалдаг болгох, нийгмийн сүлжээ, клип, шторк, импортын болон дотоодын кино, нэвтрүүлэгт тамхи хэрэглэсэн үйлдлийг үзэгчдэд харагдахааргүй болгон бүдэгрүүлэх заалтыг хуулинд оруулах, хариуцлага ногдуулах.

Тавдугаарт, ДЭМБ-ын ТХСК-ийн 5.2(а) дахь хэсэгт заасны дагуу гишүүн орнууд тамхины хяналтын салбар хоорондын үндэсний зохицуулалтын механизм байгуулах буюу хариуцах албан тушаалтныг тохоон томилох ёстой. Түүнчлэн ТХСК-ийн Нарийн бичгийн даргын газраар ахлуулсан, ДЭМБ-ын Халдварт бус өвчин(ХБӨ)-өөс урьдчилан сэргийлэх газар болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төлөөллөөс бүрдсэн олон улсын шинжээчдийн баг зөвлөмжид “Монгол Улсад тамхины хяналтын удирдлага зохицуулалтыг Эрүүл мэндийн яам(ЭМЯ)-ны албан тушаалтан хариуцаж байгаа боловч тэрээр тамхины хяналтаас гадна бусад цөөнгүй асуудал, хөтөлбөр давхар хариуцдаг. Тамхины хяналтын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа нь хууль, тогтоомжийн үр дүнтэй байдлыг сулруулж байна. Иймд ЭМЯ-ны зүгээс мэргэжлийн хяналт, гааль, цагдаа болон хууль сахиулах бусад байгууллагатай хамтарч Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Засгийн газрын байгууллагууд нэгдсэн байдлаар ажиллах үндэсний зохицуулах механизм бий болгохыг зөвлөсөн. Тамхины хяналт бол багийн ажиллагаа болохыг “Global Tobacco Epidemic 2021” гарын авлагад тодорхойлсон. Өнөөгийн байдлаар Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх үүргийг хэд хэдэн яам, агентлаг хүлээдэг боловч мөн л давхар ажил хариуцдаг, хүний нөөц олон удаа солигддог зэргээс шалтгаалан тэдний мэдлэг, оролцоо сул, хуулийн хэрэгжилт болон ТХСК-ийн зарчим, зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжиж боломж хангалтгүй, түүнчлэн тамхи үйлдвэрлэгчид, худалдаалагчдын сөрөг нөлөөнд автах, тамхины хяналтын чиглэлээрх хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хүн амын эрүүл мэндийн хамгаалах бодлогыг үндэсний хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт, давхардал хийдлийг зохицуулах үүрэг бүхий салбар хоорондын үндэсний зохицуулах механизмыг хуулинд тусган албан ёсоор байгуулж ажиллуулах.

Зургадугаарт, ТХСК-ийн Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протоколд Монгол улс 2014 онд нэгдэн орсон. Гэвч тамхины хяналтын хуулийн хэрэгжилт хангалтгүй, тамхины хууль бус худалдааг илрүүлэх, бүртгэх, хянах тогтолцоо сул, тамхины үйлдвэрлэлийн ил тод байдал ТХСК-ийн шаардлагыг хангахгүй байгаа зэрэг зөрчил байсаар байна. Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны хяналтыг сайжруулах зорилгоор тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны тодорхойлолтыг тодорхой болгох, илрүүлэх хяналтыг сайжруулах зохицуулалтыг тус хуульд оруулах,

Долдугаарт, ТХСК-ийн 17 ба 18 дугаар Удирдамжид тамхи тариаланчид болон бусад ажилчдыг тамхинаас өөр амьжиргааны тогтвортой эх үүсвэрээр хангах шинэлэг механизм бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэхийг Гишүүн орнуудад зөвлөдөг. Мөн дэлхийн тамхины үйлдвэрлэл нь тамхины тариалалтаас хамаардаг төрөлжсөн олигополи болохыг тодорхойлсон. Дэлхийн томоохон тамхи үйлдвэрлэгчид зэрэг цөөнгүй улс оронд тамхи тариалахаас бусад амьжиргааны эх үүсвэр бий болгоход анхаарч байна. Дэлхийн өөр өөр бүс нутагт хийсэн судалгаануудаар тамхины тариалалтыг орлох эдийн засгийн тогтвортой хэд хэдэн эх үүсвэрийг тодорхойлсон байна. Тамхи тариаланчдын дунд тамхины ногоон эмгэг, пестицидын хордлого, амьсгалын замын болон арьсны өвчин, хорт хавдар зэрэг ажил мэргэжлийн онцлогтой холбоотой эрсдэлүүд байдаг. Тамхи тариаланчдад өвөрмөцөөр илэрдэг

тамхины ногоон эмгэг нь никотин арьсаар шимэгдсэнтэй холбоотой үүсдэг бөгөөд нойтон навчтай харьцах үед эрсдэл нь нэмэгддэг боловч зохих хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэснээр сэргийлэх бүрэн боломжтой юм. Биди хийх явцад тамхины тоосонцроор амьсгаласнаас нэн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд амьсгалын замын өвчин эмгэг үүсдэг. Мөн энэ нь нэг байрлалд удаан хугацаагаар сууж хийдэг ажил учраас яс, булчингийн эмгэгт хүргэдэг байна.

Тамхи тариалах нь нийгмийн доройтлыг ядуурал, шударга бус гэрээ, өрийн боолчлол, хүүхдийн хөдөлмөр зэрэгтэй уялддаг тул хөгжлийн хандлагад сөрөг нөлөөтэй. Хөгжиж буй цөөнгүй улс оронд тамхины тариалалт нь биологийн төрөл зүйлийн хорогдол, ургамлын аймгийн өөрчлөлтөд хүргэж байгаа нь тамхины навчийг хатаах түлш гаргаж авах, тариалангийн талбай чөлөөлөх (удаан ашигласан талбайн хөрсөн дэх шим тэжээл хорогдсоны улмаас шинээр талбай чөлөөлөх) зорилгоор ой мод ихээр сүйтгэдэг байна. Тамхи тариалахад дэлхийн ХАА-н нийт газар нутгийн 1 хүрэхгүй хувийг ашигладаг боловч ой мод сүйтгэхэд үзүүлж буй нөлөө нь үүнээс их байна. Зарим улсад хийсэн судалгаагаар тамхи тариалах нь ой сүйдэхэд нөлөөлдөг бусад бүх хүчин зүйлийн нийлбэрээс 10 дахин илүү хор хөнөөл учруулдаг гэсэн үр дүн гарсан. Ой сүйдсэнтэй холбоотой нийгмийн-экологийн алдагдлын сөрөг үр дагаврыг тариаланчид дангаараа үүрдэг байна. Тамхийг өөр үр тариатай ээлжлэн тариалдаггүй тул хөрсөн дэх шим тэжээл шавхагдахад хүргэдэг. Тамхи тариалахад нэгж талбайд шаардагдах пестицид, бордооны хэрэгцээ зарим нөхцөлд асар өндөр байдаг” болохыг мэдээлсэн байдаг. Иймээс хүний эрүүл мэнд, хөгжил, нийгэм эдийн засаг, байгаль орчинд хор хөнөөлтэй байгаа тамхины газар тариалан эрхлэх асуудлыг эртнээс хориглож, Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхины ургамал тариалах, газар тариалан эрхлэхийг хориглох,

Наймдугаарт, ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн 14 дүгээр зүйлд “Оролцогч талууд шинжлэх ухааны нотолгоо, шилдэг туршлагад тулгуурлан, үндэсний нөхцөл байдал болон тэргүүлэх чиглэлийг харгалзан зохистой, цогц, нэгдсэн удирдамж боловсруулан, түгээж, тамхинаас гарах, тамхинд донтолтыг зохих ёсоор эмчлэх үр дүнтэй арга хэмжээ авна” гэж заасан. Тус удирдамж нь тамхинаас гарахыг хөхиүлэн дэмжих, тамхинд донтолтын эмчилгээний асуудлыг үндэсний тамхины хяналтын хөтөлбөр болон эрүүл мэндийн тогтолцоонд нэгтгэн үе шаттай хөгжүүлэхийг зөвлөдөг. Дэлхийн тамхины тархалтын 2019 оны гарын авлагын 39 дүгээр хуудсанд тамхинаас гаргах эм, бэлдмэл, ач холбогдол, хэрэглэх арга хэлбэрийг тусган хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

ДЭМБ-ын 2020 онд хийсэн “Монгол улсын тамхи хаях, тамхины хамаарлын эмчилгээний өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ”-нд Монгол улсад тамхинаас гарах эмчилгээ хийх, оновчтой зөвлөгөө өгөх бүтэц, тогтолцоо сул, ДЭМБ-ын зөвшөөрсөн тамхинаас гаргах эм,бэлдмэл эмийн бүртгэлд ороогүй, зайлшгүй шаардлагатай эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, эмийн сангуудад хангамж бараг байхгүй байгаа бол харин эмийн сангуудад ДЭМБ-ын зөвшөөрсөн эмийн жагсаалтад байхгүй тамхинаас гаргах эм бэлдмэл нэрийн дор БНСУ-ын “No Smoke” бэлдмэл зарагдаж байна. Энэ нь тамхинаас гаргах бэлдмэл биш болохыг СЭМҮТ удаа дараа мэдээлж байна. Иймээс Тамхины хяналтын тухай хуулинд ТХСК-ийн 14 дүгээр Удирдамжийн хэрэгжилтийг хангах эрхзүйн орчин бүрдүүлэх зорилгоор ДЭМБ-ын хүлээн зөвшөөрөөгүй тамхинаас

гаргах эм, бэлдмэлийг худалдахыг хориглож тамхинаас гарах хүсэлтэй иргэдийн төрөөгдлийг арилгах,

Есдүгээрт, Янжуур тамхинд болон дүнсэн тамхинд онцгой албан татвар ногдуулдаг. Энэхүү татварыг 2018-2020 онд үе шаттайгаар 20 хувиар нэмэгдүүлсэн боловч энэ нь тамхины үнэд нөлөөлөөгүйгээс гадна тамхины хэрэглээ буурахад дорвитой нөлөөлж чадахгүй байна. Манай улсад зарагдаж байгаа тамхинд ногдуулах татварын дарамт нь 42.4 хувьтай байгаа татвар, үнэ бага орны тоонд орсоор байна (WHO “Global Tobacco Epidemic 2021, page 161”). ТХСК-ийн тамхинд ногдуулах татварын зөвлөмж хэмжээ 70 хувьд хүргэхийн тулд 300 хувь нэмж тус зорилтод хүрэх боломжтойг ТХСК-ийн 22 дугаар заалтын дагуу байгуулагдсан “Мэдлэгийн хаб”-ын эдийн үнэлээчид 2022 оны 3 сарын 21-25-нд болсон “Тамхины татвар ба хууль бус худалдаа” дэлхийн цахим сургалтаар тамхины татварыг TETSIM аргачиллаар тооцолж гарган зөвлөмж болгосон. Гэвч манай тамхинд ногдуулах татвар нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бууралт, хүн амын орлогын түвшний өсөлттэй ямарч уялдаагүй байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд улс орны зах зээлд худалдаа нь өргөжиж, хэрэглээ нь эрчимтэй нэмэгдэж байгаа электрон, тамхи халаадаг тамхи, усан тамхи зэрэг нь Тамхины хяналтын тухай хуулинд зохицуулагддаггүй тул татвар төлдөггүй, хүүхэд залуучууд болон тамхи хэрэглэгчид тамхинаас гаргах хэрэгсэл гэж андуурч хэрэглэх нь нэмэгдсэн. Түүнчлэн НҮБ-ын шинжээчид “ДЭМБ-ын ТХСК-ийн 6 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн зорилтууд болон гишүүн орнуудын 6 дугаар хурлаар баталсан холбогдох Удирдамжуудыг хэрэгжүүлж чадахгүйд хүрч байна. Иймд ТХСК-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварыг нэмэхийг Монгол Улсад зөвлөмж болгосон”.

Өнөөгийн байдлаар тамхи импортлох тусгай зөвшөөрөлтэй 14 аж ахуйн нэгж байна. Засгийн газраас 1997 оноос эхлэн 8 аж ахуйн нэгжид тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгосноор 2002 оноос тамхины үйлдвэрлэл, борлуулалт эхэлсэн. Өнөөгийн байдлаар нэг компани тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тамхи импортлох, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн иргэн, компаниудын тусгай зөвшөөрлийн асуудлыг зохицуулах эрх зүйн заалт байхгүй байна.

Аравдугаарт, Импортлох тамхины нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан ил тод сонгон шалгаруулалт явуулах талаар эрх зүйн орчин бүрдээгүйгээс тамхины импортын хэмжээ жилээс жилд өсөх хандлагатай байна. Тухайлбал, мөнгөн дүнгээр тооцсон мэдээллээс харахад, импорт 2014 онтой харьцуулахад 2015 онд 3,4 хувиар өссөн. “Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтад тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгахаар заасан боловч тамхи импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг заагаагүй байна. Үүнээс дүгнэхэд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хуулийг зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Ерөнхий зорилго: “Тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалахад чиглэгдэнэ.”

Хэрэгжүүлэх зорилт:

1. Тамхи, тамхин бүтээгдэхүүний тухай ойлголтыг өргөжүүлж, тодорхой болгон хуульд тусгагдаагүй байсан шинэ болон шинээр гарч ирж байгаа тамхины төрлүүдийг тамхин бүтээгдэхүүн гэсэн тодорхойлолтод тусгаж томьёолох,
2. Дотоод орчныг 100% тамхигүй орчин болгож, аливаа байгууллагын орох хаалганы гадна талаас 10-50 метрт зайд тамхи татах цэгийг байгуулж тамхины утаанд өртөлтийг багасгана.
3. Тамхины шинэ төрлүүд/электрон тамхи, халаадаг тамхи, зажилдаг тамхи/ болон дахин сэргэж байгаа тамхи/усан тамхи/-ийг бусад тамхины адилаар Тамхины хяналтын тухай хуулийн зохицуулалтад хамруулах,
4. Тамхины хайрцагны ар болон нүүрэн талын талбайн хэсгийн эрүүл мэндийн зурагт анхааруулгын хэмжээг 70%, бичвэр анхааруулгыг тамхины таглааны нүүрэн талын хэсэгт байрлуулж, тамхи хаях сэдлийг сайжруулах,
5. Худалдааны байгууллагад тамхийг биет байдлаар ил харагдахааргүй байдлаар байршуулж тамхи татах донг сэдрээх нөлөөллийг бууруулах,
6. Нийгмийн сүлжээ, клип, шторк, импортын болон дотоодын кино, нэвтрүүлэгт тамхи хэрэглэсэн үйлдлийг үзэгчдэд харагдахааргүй болгон бүдэгрүүлж байх заалтыг хуулинд оруулах, хариуцлага ногдуулах,
7. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг зохицуулах салбар хоорондын үндэсний зохицуулах механизмыг албан ёсоор байгуулах нөхцлийг хуулинд тусгах,
8. Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг илрүүлэх хяналтыг сайжруулах эрхзүйн орчин бүрдүүлэх,
9. ТХСК-ийн 14 дүгээр Удирдамжийн хэрэгжилтийг хангаж, тамхины хамаарлын эмчилгээний эм, бэлдмэлийн хүртээмж, хангамжийг сайжруулах, хууль бус эм бэлдмэлийг хориглох,
10. Тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг импортлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан ил тод сонгон шалгаруулалт явуулдаг болох,
11. Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлт гаргаагүй бол

тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцох эрх зүйн боломж бүрдэж, тамхины импортын хэмжээ буурахад нөлөөлнө.

12. Дэлхий нийтэд тамхины ургамал тариалалтыг багасгаж ажилчдыг тамхинаас өөр амьжиргааны тогтвортой эх үүсвэрээр хангах бодлогод шилжих зөвлөмжийг өгч байгаа тул Тамхины хяналтын тухай хуульд тамхины ургамал тариалахыг хориглох.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хоёрдугаар хэсэгт заасан зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Зохицуулалтын хувилбар	Харьцуулалт		Үр дүн
	Эерэг	Сөрөг	
1. “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Асуудлын зорилго хангагдахгүй учраас тэг зохицуулалт манай тохиолдолд шаардлагагүй.	-Тамхины хэрэглээ буурахгүй -Улс орнуудаас шахагдаж, тамхи үйлдвэрлэгчид хуулийн зохицуулалт муутай улс оронд шинэ болон дахин сэргэж байгаа тамхины импортыг нэмэгдүүлнэ. -Электрон тамхи, усан тамхи болон навсай/Киргиз тамхи/ мэтийн эртний гэсэн тодотголтой тамхины хэрэглээ нэмэгдэнэ. -Тамхи хаях хүсэлтэй, оролдлого хийх тамхи хэрэглэгчдийн хувь буурна. -Хэрэв 15 жилийн хугацаанд юу ч хийхгүй бол тамхины хэрэглээ нэмэгдэж, 192,985 ЗСӨ-ний (цус харвалт, ЗЦХӨ) тохиолдол цагаас эрт гарах тооцоолол бий /НҮБ-ХОҮӨ судалгаа/. -НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 3.4 дэх зорилт хангагдахгүй. -ТХСК-ийн өмнө хүлээсэн үүрэг амлалт биелэгдэхгүй.	-НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 3.4 дэх зорилт ХБӨ-ийг 25 хувиар бууруулах зорилт хангагдахгүй -ТХСК-ийн өмнө Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалт, зөвлөмж биелэгдэхгүй. -Хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж, тамхинаас шалтгаалах өвчлөл, нас баралт нэмэгдэж, эдийн засгийн алдагдал нэмэгдэж,

			тамхитай холбоотой өвчлөлийн эмчилгээ, үйлчилгээний зардал нэмэгдэнэ.
2.Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	ДЭМБ-аас мэдээл сурталчилгаа нь үр дүнгээ маш удаан, урт хугацаанд өгдөг , үр дүн багатай арга хэмжээнд тооцогддог. Тамхитай тэмцэх цогц арга хэмжээний зөвхөн нэг л тал.	-Тамхитай тэмцэх нь нийгэм, эдийн засгийн олон салбарын оролцоотой олон талт арга хэмжээг шаарддаг бөгөөд тамхи нь химийн хөнөөлийн нөлөөлөл их, донтолт ихтэй бүтээгдэхүүнд тооцогддог. -ДЭМБ-аас ширхэг тамхи ч хортойг зарласан. -Тамхитай тэмцэх зардал бараг байхгүй, хэвлэл мэдээллийн өртөг маш их байгаа үед хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх ажил хийсэн ч үр дүн маш хангалтгүй. Оновчгүй шийдэл болно.	Үр дүн багатай. Хэвлэл мэдээллийн өртөг маш их байгаа үед улсын төсвөөс маш их зардал гарна. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.
3.Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн механизмаар буюу татвар, хураамжийн бодлого, лиценз зөвшөөрөл зэргээр хязгаарлалт тогтоох зэрэг зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь энэхүү төслийн хувьд тохиромжгүй юм.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй. Төсвөөс бага зэрэг зардал гарна.
4.Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс тамхинд ногдуулах онцгой албан татварыг нэмж тамхины үнийг нэмэх нь тамхины хэрэглээг бууруулах хамгийн үр дүнтэй арга. Тамхины хяналтын бусад арга хэмжээг төрийн тогтмол санхүүжилттэй болгох нь үр дүн	Тамхины хяналтын бусад арга хэмжээг төрийн тогтмол санхүүжилттэй болгох нь үр дүн өгнө. Гэхдээ энэ хуулийн өөрчлөлтөд зохицуулалт хийгдэхгүй төсвөөс хөрөнгө гарахгүй.	Зардал өндөртэй, үр дүн гарна. Гэхдээ энэ хуулийн төсөлд захиргаа, эрх зүйн зохицуулалт хийх замаар зорилгод хүрэх боломжтой.

	өгнө. Гэхдээ энэ хуулийн өөрчлөлтөд зохицуулалт хийгдэхгүй.		
5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Тамхины хяналтын тухай хуулийн 5.1.3-т “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, олон нийтийн боловсрол олгох чиглэлээр тамхи үйлдвэрлэгч, эсхүл түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээд, иргэдтэй хамтран ажиллахаас татгалзах”-ыг төрийн байгууллагын үүрэгт заасан байна.	Бусад хүний эрхийг хамгаалах үүднээс хууль ёсны эрхийн хязгаарлалт хийх нь төрийн үүрэг учраас энэхүү хуулийн төслийн зорилгод хүрэх зорилтууд нь төрийн зохицуулалтаар хийгдэх харилцаа тул энэ зохицуулалтын хувилбарын хувьд оновчгүй учраас төрийн бус байгууллага, хувийн хэвшил оролцох боломжгүй.	Бусад хүний эрхийг хамгаалах үүднээс хууль ёсны эрхийн хязгаарлалт хийх ажлыг ТББ, хувийн хэвшил хийх нь үр дүнгүй, гэрээгээр гүйцэтгүүлэх тул төсвөөс зардал гарна.
6.Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр нь хязгаарлагдмал зохицуулалт болох тул тамхины хэрэглээг бууруулах үр дүнд хүрч чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр дүн багатай.
7.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.	Дам тамхидалт, тамхины хорт үр дагавраас хүн амыг хамгаалах, нийтийн эрүүл мэнд, хөгжлийн эрх ашгийг хамгаалахад тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарахгүй, гэхдээ энэ нь асуудлуудыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй, төсвөөс зардал гарахгүй гэж үзэж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3-д “Бичгээр гаргасан захиргааны акт дараах шаардлагыг хангасан байна. Захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах” гэж заасны дагуу энэ тохиолдолд “хууль

тогтоомжийн төсөл боловсруулах” гэсэн зохицуулалтын хувилбар нь сонгогдлоо. Уг зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлахад:

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр Нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм			
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм		

агуулсан эсэх	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм		
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм		
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм		
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	тийм	
		Тийм	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	

	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм		
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм		
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн		Үгүй	

		зохицуулалт бий болгох эсэх			
6.Инноваци судалгаа шинжилгээ болон		6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх			хамааралгүй
		6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх			хамааралгүй
7.Хэрэглэгч гэр бүлийн төсөв болон		7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
		7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх			хамааралгүй
		7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	
		7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Тодорхой нутаг, салбарууд бүс		8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
		8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
		8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хамааралгүй
9.Төрийн захиргааны байгууллага		9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
		9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
		9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
10.Макро засгийн хүрээнд эдийн		10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
		10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах	Тийм		

	зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх			
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм		
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	

4.Төрийн удирдлага, засаглал, шүүх эрх мэдэл, мэдээлэл, суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм		
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм		
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	

	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

Хүснэгт 4

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	

	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх			хамааралгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх			хамааралгүй

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Тамхины хяналтын суурь конвенцийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтад "... бүс нутгийн болон олон улсын хэлэлцээрээс гадна үндэсний хууль тогтоомжийг боловсруулж хэрэгжүүлэх нь тамхины хяналтын салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд мөн..." гэж заасан байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон тамхины эрэлтийг бууруулах, дам тамхидалтын сөрөг нөлөөллөөс иргэдийг хамгаалах, тамхины нийлүүлэлтийн зохицуулалтын хүрээнд нийгмийн харилцаанд үүссэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбар нь Тамхины хяналтын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ цаг хугацаанд хамгийн үр дүнтэй хувилбар гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж, 10.3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах” эрхтэй гэж, 6 дахь дахь заалтад “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах” эрхтэй гэж тус тус заасан.

Иймээс Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн **чиглэлээрх** Монгол Улсын олон улсын гэрээний агуулга, зарчимд нийцнэ гэж дүгнэж байна.

ЗУРГАА.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Тамхидалттай холбоотой өвчлөл, эрт нас баралт, хамгийн бүтээмж өндөртэй үе дээрээ тахир дутуу болох гэх мэт өндөр өртөг нь тамхины хэрэглээг хязгаарлах арга хэмжээний эдийн засгийн бодит үндэслэлийг бий болгож байна. Тамхидалт нь эрүүл мэнд, орлого, орлого олох потенциал, хөдөлмөрийн үр бүтээмжид сөрөг нөлөөтэй. Мөн тамхидалт нь нийгэм, эдийн засгийн хүртээмжтэй хөгжлийг бий болгох амин чухал хүчин зүйлсийн нэг болох хүний хөгжлийг сааруулдаг. /Эх сурвалж: <http://blogs.worldbank.org/eastasiapacific/mn/recent-gains-global-tobacco-taxation/>

Тамхины чимээгүй тахалтай тэмцэх асуудал зөвхөн хүний эрүүл мэндийн асуудал төдийгүй бүхэл бүтэн улс, үндэстэн төдийгүй дэлхий нийтийн хөгжлийн тулгамдсан асуудал болж байгааг харгалзан Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/-ын санаачилгаар 1999 оноос “Тамхины хяналтын суурь конвенци”(ТХСК)-ийг боловсруулж, 2003 онд ДЭМБ-ын 56 дугаар Чуулганаар баталж, 2005 оноос эхлэн хүчин төгөлдөр болон хэрэгжиж байна. Тус Конвенци болон түүнийг дагаж батлагдсан найман Удирдамж, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протокол /2018 оны 9 сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн/-ыг батлан мөрдөхийг Гишүүн улс орнуудад зөвлөмж болгодог.

НҮБ-ын 2030 он хүртэлх “Тогтвортой хөгжлийн зорилтын 3.4 дэх зорилт”-ыг хангах 3.а шалгуур үзүүлэлтэд ТХСК-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудал тусгагдсан.

ТХСК-ийн Нарийн бичгийн дарга нарын газраас хоёр жил тутам Дэлхийн эрүүл мэнд байгууллагын Тамхины хяналтын суурь конвенцийн оролцогч Талуудын бага хурлыг зохион байгуулж, тамхин бүтээгдэхүүний хэрэглээ, үйлдвэрлэл нь байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа талаар болон тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах, шинээр гарч буй тамхин бүтээгдэхүүн, тамхины хяналтын үйл ажиллагаанд үзүүлэх тамхи үйлдвэрлэгчдийн нөлөөг арилгах ажлын явц түүнчлэн, олон улсын хэмжээнд тамхины хяналтыг сайжруулах, конвенцийн хэрэгжилтийг

хангах чиглэлээр ирэх таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажлыг тодорхойлж, Дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулж, ДЭМБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлан мөрдөж байна.

Өнөөгийн байдлаар тус конвенцид 182 улс орон нэгдэж, дэлхийн нийт хүн амын 90 гаруй хувь тамхины хяналтад орж, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах Протоколд 63 орон нэгдэж /2021/, улс орон бүр олон талт бодлого, арга хэмжээг үндэсний хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна. Энэхүү конвенци нь тамхины хэрэглээ болон тамхины утаанд нэрвэгдэх явдлыг бууруулах, тамхидах тахлын эрүүл мэнд, нийгэм, байгаль орчин, эдийн засагт учруулах сөрөг үр дагавраас одоо ба хойч үеийнхнийг хамгаалах зорилготой нийгмийн эрүүл мэндийн анхны олон улсын хууль эрх зүйн баримт бичиг юм.

Монгол Улс энэхүү конвенцийг дэмжин Монгол Улсын Засгийн газар 2003 оны 6 дугаар сарын 16-ны өдөр гарын үсэг зурж, тус конвенцийг 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурал соёрхон баталсныг Нэгдсэн Үндэстний Байгууллага 2004 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр албан ёсоор бүртгэж авсан бөгөөд Монгол Улсад 2005 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөж байна. Тус конвенцийн “Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протокол”-ыг Монгол Улсын Их Хурал 2014 онд соёрхон баталсан.

Тамхины хяналтын суурь конвенци нь нийтийн эрүүл мэндийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чухал механизмын нэг. Конвенцийн мөрөөр гишүүн орнууд өргөн хүрээтэй тамхины хяналтын хууль батлахын зэрэгцээ тамхины татварыг нэмэх, тамхигүй орчныг бүрдүүлэх, дам тамхидалтаас хамгаалах, тамхины сурталчилгааны эрх зүйн зохицуулалт бий болгох зэрэг олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. /Эх сурвалж: ГХЯ/.

Монгол Улсын Их Хурал анх Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийг 1993 онд баталж, Монгол Улсын Засгийн газраас “Тамхины хяналтын суурь конвенц” (ТХСК)-ийн ерөнхий зарчим, арга хэмжээнүүдийг дотоодынхоо нөхцөл байдалтай уялдуулан уг хуулийн шинэчилсэн найруулгыг 2005 оны 07 дугаар 01-ний өдөр баталж, түүнд 2012 онд 1 удаа, 2015 онд 3 удаа, 2019 онд 1 удаа, нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуульд Улсын Их Хурлын гишүүнээр санаачилгаар 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр оруулсан өөрчлөлт нь ТХСК-ийн зарчим, заалтаас ухарсан заалт болсныг НҮБ-ын шинжээчид дүгнэсэн. Тамхины хяналтын тухай хуулиас гадна Онцгой албан татварын тухай хуулиар 100ш янжуурт 4180 төгрөг, задгай тамхинд 3130 төгрөгийн татварыг, Гаалийн албан татварын тухай хуулиар 10 хувийн татвар, худалдаанд 10 хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж байна.

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр /ГАТТ/, Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-ын Импортын лицензийн журмын тухай хэлэлцээрийн гол зарчим нь импортын лиценз нь худалдааны бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд лицензийн журам ил тод байх, импортод хориг саадын нөлөөлөл үзүүлэхгүй байх, түүнийг засаг захиргааны аль нэг байгууллагаас олгож байх, хүсэлт гаргасан гишүүн оронд импортын лиценз олголт, импортын лицензтэй барааны талаар статистик мэдээлэл өгч байх явдал юм. Монгол Улс ДХБ-д нэгдэн орсноос хойш импортын лицензийн

хүчинтэй байх хугацааг нэг жил болгож сунгах, лицензийн тогтолцоог хүн, амьтан, ургамал болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах зорилгоор хэрэглэх, лицензийн журам, хэрэгжилтийн явцыг ДХБ-д мэдээлж байх үүрэг амлалт авсан байна. /Эх сурвалж: ДХБ- Олон улсын худалдааны хэлэлцээрийн үе шат ба Монгол Улс. Д.Оюунбат, Х.Эрдэнэчулуун <http://orkhoncustoms.mn/885/>.

НҮБ-аас манай улсад шинжээчдээ ажиллуулан 2015 онд “Тамхины хяналтын суурь конвенцийн хэрэгжилтийн үнэлгээ”-г хийлгэж, 14 заалт бүхий зөвлөмж, 2021 онд “Тамхины хяналтын суурь конвенцийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийн судалгаа”-г хийлгэж, тамхидалтай тэмцэх нь эдийн засгийн үр өгөөжтэй арга хэмжээ болохыг баталж, олон мянган хүний амийг аврах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой гэсэн дүгнэлт, зөвлөмж өгсөн байна. Эдгээр зөвлөмжид байгууллагын дотоод орчныг 100 хувь тамхигүй орчин болгох, тамхины эрүүл мэндийн зурагт анхааруулгын хэмжээг нэмэх, татварыг үе шаттай нэмэх, хууль бус худалдаатай тэмцэх, тамхинд донтолтыг бууруулах зэрэг арга хэмжээг хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

Дэлхийн олон оронд тамхины эсрэг хуулийг батлан хэрэгжүүлдэг нь тамхи татдаггүй хүмүүсийн эрхийг хамгаалах, дам тамхидалтаас хүмүүсийг хамгаалахад чиглэдгээрээ онцлогтой.

ДЭМБ-ын ТХСК-ийн Газраас Гишүүн орнуудын Засгийн газраас баталсан асуумжийн дагуу 2008 оноос эхлэн судалгаа авч нэгтгэн “WHO Report on the Global Tobacco Epidemic” тайланг гаргаж хэвлүүлэн өөрийн вебсайтад ил тод байрлуулж, шийдвэр гаргах, бодлого арга хэмжээгээ хэрэгжүүлэхэд ашигладаг бөгөөд 2021 онд 8 дахь удаагийн гарын авлага хэвлэгдэн гарсан байна.

Тамхины хяналтын туай хуульд өөрчлөлт оруулах зорилттой холбогдуулан зарим улс орны туршлага, дэвшилтэт арга хэмжээнээс дурдвал:

ТХСК-ийн Гишүүн улс орнуудын 6 дугаар хурлаас /COP6, 2014 он/ шинэ болон дахин сэргэж байгаа тамхин бүтээгдэхүүнийг, ялангуяа халаадаг тамхи, электрон тамхи, никотингүй электрон тамхийг хориглох, зохицуулалт хийхийг, 2016 онд болсон COP7-оос эдгээрийг үйлдвэрлэх, импортлох, тараах, танилцуулах, худалдах, хэрэглэхийг хориглож хууль тогтоомждоо бусад тамхин бүтээгдэхүүний адилаар тусгаж зохицуулахыг зөвлөсөн /хуудас 26/.

2021 оны байдлаар 111 улсад электрон тамхийг ямар нэгэн хэмжээгээр зохицуулалт хийж, үүнээс 32 улс электрон тамхийг худалдаалахыг хуулиар хориглож, /үүнд: өндөр хөгжилтэй 8 улс, дунд орлоготой 18 улс, бага орлоготой 5 улс байна./, 79 орон нь хуулийн зохицуулалт /ОХУ, БНХАУ, БНСУ гэх мэт /хуудас 101/ хийсэн бол 86 оронд татвар ногдуулсан /3 улсад жижиглэнгийн үнийн 75 хувиас дээш /хуудас 22, 102-103/ байна. 2021 оны 10 сараас эхлэн Австрали улс электрон тамхийг импортлох, худалдахыг хориглосон анхны улс болсон /хуудас 39/.

Хүн амыг тамхины утааны хор хөнөөлөөс хамгаалах зорилгоор 195 улс тамхигүй орчин бүрдүүлж байгаагаас 67 улсад олон нийтийн бүх газарт 100 хувь

тамхигүй орчинтой, 29 улсад 6-7 олон нийтийн газарт, 99 улс оронд 2-5 олон нийтийн газарт тамхи татахыг хориглосон байна /хуудас 66/.

Ихэнх тамхи хэрэглэгчид тамхины хор хөнөөлийг сайн мэддэггүй учраас тамхины хайрцаг, сав баглаан дээр тамхины хор хөнөөлийн эрүүл мэндийн зурагт анхаарулга тавихыг ТХСК шаарддаг. Тамхи хэрэглэгчдийн 80 гаруй хувь нь эрүүл мэндийн зурагт анхааруулгыг хараад тамхи хаяхыг боддог, оролдлого хийдэг, зарим нь ч тамхинаас гардаг. Өнөөгийн байдлаар 101 оронд бүх шаардлагыг хангасан 70 хувь хүртэлх эрүүл мэндийн анхааруулгатай, 51 оронд 50 болон түүнээс доош хувийг эзэлсэн анхааруулгатай байна. 17 улс оронд тамхины хайрцагны өнгийг нэг өнгөтэй бор болгосон байна /хуудас 74/.

ТХСК-ийн “Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протокол”-д Монгол Улс 2014 онд элссэн бөгөөд 2021 оны байдлаар дэлхийн 63 орон нэгдээд байна. Монгол Улс тамхины бүтээгдэхүүний хангамжийн сүлжээнд бүрэн хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх үүргийг хүлээсэн. Тамхины эрэлт буурч байгаатай холбоотойгоор тамхи үйлдвэрлэгчид, худалдаалагчид татвараас зайлсхийх, хуурамч бүртгэлгүй татварын шошго үйлдвэрлэх, тамхин бүтээгдэхүүний стандартыг зөрчих, хуульчлаагүй шинэ төрөл болгох зэрэг хууль бус үйлдлүүд эрчимжиж байна. Монгол Улс тамхи үйлдвэрлэгч, экспортлогч 2 том орны дунд байдагтай холбоотойгоор тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг илрүүлэх, татвараас зайлсхийх явдлыг устгах тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай.

Сүүлийн 2 жилд дундад азийн 17 орон усан тамхи буюу шиша тамхийг олон нийтийн газар хэрэглэхийг хориглосон.

Польш Улс тамхи импортлох тоо хэмжээг тогтоож өгдөг бөгөөд тухайлбал, Унгар Улсаас жилд 700 тн боловсруулалт хийгээгүй тамхи импортлох хэмжээг тогтоож өгсөн байдаг. /Эх сурвалж: <http://adic-ukraine.narod.ru/adic/reports/econ/ch-6/6-1.htm/>.

Вьетнам Улсын Үйлдвэр, худалдааны яам 2017 оны 3 сарын 14-нөөс 2019 оныг дуустал Евразийн эдийн засгийн холбооны орнуудаас жилд 500 тн янжуур тамхи импортлох тоо хэмжээг тогтоосон зохицуулалтыг хэрэгжүүлдэг. /Эх сурвалж: <http://english.vietnamnet.vn/fms/business/173038/vietnam-sets-import-quotas-for-eggs--cigarettes.html/>.

Тайландын Вант Улсад тамхи импортлоход квот тогтоодог бөгөөд 60 хувийн татвар ногдуулдаг байна.

Саудын Арабын Вант Улс тамхи импортлоход квот тогтоодоггүй боловч 100 хувийн татвар авдаг байна. /Эх сурвалж: <http://www.eurasiancommission.org/ru/act/>

Япон Улсад тамхины импортод улсын монополь тогтоож, тамхины импортын асуудлыг Японы Сангийн яам 67 хувийг нь эзэмшдэг тамхины компани хариуцан зохицуулдаг бөгөөд тамхины борлуулалт, дотоодын худалдаалагчдын үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг хариуцан ажилладаг байна.

БНХАУ-д импортын барааг, түүний дотор тамхи, тамхин бүтээгдэхүүнийг багтаан гадаад эдийн засгийн үйл ажиллагаанаас үндэсний эрх ашгаа хамгаалах үүднээс импорт, экспорт хариуцсан 10 гаруй групп ажилладаг байна.

БНСУ-д зөвшөөрөл олгож, бүртгэдэг бөгөөд зөвшөөрөл авч бүртгүүлснээс хойш 1 жил үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаагүй бол зөвшөөрлийг цуцалдаг байна.

ОХУ-д тамхины импортыг хязгаарладаг бөгөөд 1000 ш янжуур тамхинд 15,7 евро, фильтргүй тамхи /папирос/-д 100 ш-т 9,0 евро ногдуулдаг байна. /Эх сурвалж: <http://www.kaznachey.com/doc/82hbEiOI0ov//>.

ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

Дэвшүүлсэн зорилго, зорилтдоо хүрэхийн тулд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох замаар нийгэмд үүссэн тулгамдсан асуудлыг шийдэх нь хамгийн үр дүнтэй гэж үзэж байна. Тус хуульд дараах асуудлыг тусган зохицуулах шаардлагатай:

1.Тамхи, тамхин бүтээгдэхүүний тухай ойлголтыг өргөжүүлж, тодорхой болгон хуульд тусгагдаагүй байсан шинэ болон шинээр гарч ирж байгаа тамхины төрлүүд /халаадаг тамхи, никотин бүхий электрон тамхи, усан тамхи, никотингүй электрон дамжуулах систем бүхий тамхи/ тамхин бүтээгдэхүүн гэсэн тодорхойлолтод тусгаж томъёолох.

2.Тамхины шинэ төрлүүд/электрон тамхи, халаадаг тамхи, зажилдаг тамхи/ болон дахин сэргэж байгаа тамхи/усан тамхи, навсай тамхи/ бусад тамхины адилаар хуулийн зохицуулалтад хамруулах.

3.Байгууллагын дотоод орчныг 100% тамхигүй орчин болгож, аливаа байгууллагын орох хаалганы гадна талаас 10-50 метрт зайд тамхи татах цэгийг байгуулж тамхины утаанд өртөлтийг багасгах.

4.Худалдааны байгууллагад тамхийг биет байдлаар ил харагдахааргүй байдлаар байршуулж тамхи татах сэдэл төрөх нөлөөллийг бууруулах.

5.Тамхины хайрцагны ар болон нүүрэн талын талбайн хэсгийн эрүүл мэндийн зурагт анхааруулгын хэмжээг 70%, бичвэр анхааруулгыг тамхины таглааны нүүрэн талын хэсэгт байрлуулах, эсвэл тамхины хайрцаг, сав баглаа боодлын өнгийг бор өнгөтэй болгон тамхи татах сэдлийг төрүүлэх үйлдлийг багасгах.

6.Худалдааны байгууллагад тамхийг биет байдлаар ил харагдахааргүй байдлаар байршуулж тамхи татах донг сэдрээх нөлөөллийг бууруулах.

7.Нийгмийн сүлжээ, клип, шторк, импортын болон дотоодын кино, нэвтрүүлэгт тамхи хэрэглэсэн үйлдлийг үзэгчдэд харагдахааргүй болгон бүдэгрүүлж байх заалтыг хуулинд оруулах, хариуцлага ногдуулах.

8.Тамхи татах донг сэдрээх байдлыг бууруулах зорилгоор бренд өргөтгөх зорилго бүхий бүх төрлийн зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох.

9.Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг зохицуулах салбар хоорондын үндэсний зохицуулах механизмыг албан ёсоор байгуулах нөхцлийг хуулинд тусгах.

10.Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг илрүүлэх хяналтыг сайжруулах эрхзүйн орчин бүрдүүлэх.

11.ТХСК-ийн 14 дүгээр Удирдамжийн хэрэгжилтийг хангаж, тамхины хамаарлын эмчилгээний эм, бэлдмэлийн хүртээмж, хангамжийг сайжруулах, хууль бус эм бэлдмэлийг хориглох.

12.Тамхинд ногдуулах татаварын хэмжээг ТХСК-ийн зөвлөмжид хэмжээнд хүргэх бодлогыг төрийн бодлогод тусгах.

13.Тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг импортлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан ил тод сонгон шалгаруулалт явуулдаг болох.

14.Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлт гаргаагүй бол тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцох эрх зүйн боломж бүрдэж, тамхины импортын хэмжээ буурахад нөлөөлнө.

15.Дэлхий нийтэд тамхины ургамал тариалалтыг багасгаж ажилчдыг тамхинаас өөр амьжиргааны тогтвортой эх үүсвэрээр хангах бодлогод шилжих зөвлөмжийг өгч байгаа тул Тамхины хяналтын тухай хуульд тамхины ургамал тариалахыг хориглох зэрэг болно.

-----oOo-----